



XI/2021

Тархаасан: 12 дугаар сарын 13



## Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 1.3 хувиар өслөө

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үеэс 10.5 хувь, өмнөх оны эцсээс 11.1 хувь, өмнөх сараас 1.3 хувиар өссөн байна.

ЗУРАГ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 10.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 18.7 хувь (мах, махан бүтээгдэхүүн 22.2 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 11.1 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 6.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 5.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.8 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 19.5 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 11.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 17.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 13.2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 6.4 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 19.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1.3 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.0 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 1.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.9 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 1.4 хувь тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 2.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**ХҮСНЭГТ 1. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, ХУВИАР, 2021 оны 11 дүгээр сард**

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	<u>2021 XI</u> 2020 XI	<u>2021 XI</u> 2020 XII	<u>2021 XI</u> 2021 X
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>110.5</b>	<b>111.1</b>	<b>101.3</b>
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	118.7	117.0	102.0
Согтууруулах ундаа, тамхи	4.4	106.1	106.1	101.6
Хувцас, бөс бараа, гутал	16.6	105.0	104.5	100.9
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	101.0	113.2	101.4
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	107.7	107.4	100.8
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	106.8	106.4	100.3
Тээвэр	14.4	119.5	119.5	102.4
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	102.2	102.2	100.7
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	103.0	103.0	100.2
Боловсролын үйлчилгээ	4.8	103.7	103.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	112.5	112.5	100.0
Бусад бараа, үйлчилгээ	5.4	107.0	106.6	100.5

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2018 оны 11 дүгээр сард 8.1 хувь, 2019 оны 11 дүгээр сард 5.2 хувь, 2020 оны 11 дүгээр сард 3.5 хувь гарч байсан бол 2021 оны 11 дүгээр сард 10.5 хувь болж, өмнөх оны мөн үеэс 7.0 нэгж хувиар нэмэгдсэн байна.

**ХҮСНЭГТ 2. ИНФЛЯЦАД БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГҮҮДИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгжээр, жил бүрийн 11 дүгээр сард**

Бараа, үйлчилгээний бүлэг	2018 XI	2019 XI	2020 XI	2021 XI
<b>Ерөнхий индекс</b>	<b>8.1</b>	<b>5.2</b>	<b>3.5</b>	<b>10.5</b>
Хүнсний бараа, ундаа, ус	1.9	2.4	2.0	5.0
Согтууруулах ундаа, тамхи	0.4	0.1	0.2	0.3
Хувцас, бөс бараа, гутал	0.8	1.1	0.7	0.8
Орон сууц, ус, цахилгаан, түлш	1.5	0.4	0.4	0.1
Гэр ахуйн тавилга, бараа	0.3	0.2	0.2	0.4
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.5	0.1	0.1	0.3
Тээвэр	1.6	-0.4	-0.6	2.5
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.0	0.0	0.0	0.1
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.3	0.3	0.0	0.1
Боловсролын үйлчилгээ	0.3	0.5	0.0	0.2
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.2	0.3	0.2	0.4
Бусад бараа, үйлчилгээ	0.2	0.2	0.3	0.4

Инфляцын түвшин буюу хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард улсын хэмжээнд 10.5 хувь гарсны 5.0 нэгж хувь буюу 47.6 хувь нь хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.


ХҮСНЭГТ 3. ИНФЛЯЦАД ИМПОРТЫН БАРААНЫ ҮНИЙН ӨСӨЛТИЙН ОРОЛЦОО, нэгж хувиар, жил бүрийн 11 дүгээр сард

Үзүүлэлт	2019 XI		2020 XI		2021 XI	
	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь	Нэгж хувь	Хувь
<b>Ерөнхий индекс</b>	<b>5.2</b>	<b>100.0</b>	<b>3.5</b>	<b>100.0</b>	<b>10.5</b>	<b>100.0</b>
Импортын барааны нөлөө	1.6	30.8	1.1	31.4	5.3	50.5

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байгаа бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлж байна.

Инфляц 2021 оны 11 дүгээр сард 10.5 хувь гарсны 50.5 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны үнийн өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 19.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 2. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар




Хүнсний барааны бүлгийн үнэ өмнөх оны мөн үеэс 2020 оны 11 дүгээр сард 7.3 хувиар, 2021 оны 11 дүгээр сард 17.0 хувиар өсөж, өсөлтийн хурдац 9.7 нэгж хувиар, хүнсний бус бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 11 дүгээр сард 1.9 хувиар, 2021 оны 11 дүгээр сард 7.6 хувиар өсөж, өсөлтийн хурдац 5.7 нэгж хувиар тус тус нэмэгджээ.

ХҮСНЭГТ 4. ХҮНС, ХҮНСНИЙ БУС БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, бүлгээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 11 дүгээр сард

Огноо	Хүнс, хүнсний бус	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	<b>Ерөнхий индекс</b>	<b>103.5</b>	<b>104.3</b>	<b>102.7</b>	<b>101.9</b>	<b>102.9</b>	<b>102.7</b>
2020 XI	Хүнс	107.3	108.2	106.9	106.0	106.3	103.8
	Хүнсний бус	101.9	102.6	101.2	100.4	101.5	102.3
	<b>Ерөнхий индекс</b>	<b>110.5</b>	<b>110.0</b>	<b>111.0</b>	<b>109.9</b>	<b>112.6</b>	<b>109.8</b>
2021 XI	Хүнс	117.0	117.1	115.4	116.9	118.1	115.4
	Хүнсний бус	107.6	106.5	109.3	107.2	110.2	107.4

Төвийн бүсэд 2021 оны 11 дүгээр сард хүнсний бүлгийн үнэ 18.1 хувиар, Төвийн бүсэд хүнсний бус бүлгийн үнэ 10.2 хувиар тус тус өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 3. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, сараар




Барааны бүлгийн үнэ 2020 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 4.0 хувиар, 2021 оны 11 дүгээр сард 12.2 хувиар өсөж, өсөлтийн хурдац 8.2 нэгж хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ 2020 оны 11 дүгээр сард 1.9 хувиар, 2021 оны 11 дүгээр сард 5.2 хувиар өсөж, өсөлтийн хурдац 3.3 нэгж хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 5. БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮЛГИЙН ҮНИЙН ИНДЕКС, бүсээр (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар) хувь, жил бүрийн 11 дүгээр сард

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	<b>Ерөнхий индекс</b>	<b>103.5</b>	<b>104.3</b>	<b>102.7</b>	<b>101.9</b>	<b>102.9</b>	<b>102.7</b>
2020 XI	Бараа	104.0	105.1	103.3	102.2	103.3	102.8
	Үйлчилгээ	101.9	102.5	100.5	100.5	101.1	102.3
	<b>Ерөнхий индекс</b>	<b>110.5</b>	<b>110.0</b>	<b>111.0</b>	<b>109.9</b>	<b>112.6</b>	<b>109.8</b>
2021 XI	Бараа	112.2	111.6	112.9	111.5	114.6	111.3
	Үйлчилгээ	105.2	106.0	104.5	103.8	103.9	103.5

Төвийн бүсэд 2021 оны 11 дүгээр сард барааны бүлгийн үнэ 14.6 хувиар, үйлчилгээний бүлгийн үнэ Улаанбаатар хотод 6.0 хувиар өссөн нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 4. МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үетэй харьцуулснаар), хувь, сараар



Мах, махан бүтээгдэхүүний үнэ 2021 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 21.6 хувиар өсөж, харин өмнөх сараас 0.6 хувиар буурахад үхрийн махны үнэ 0.2 хувь, ямааны махны үнэ 3.3 хувиар буурсан нь голлон нөлөөлжээ.

Харин өмнөх оны мөн үеэс 22.2 хувиар өсөхөд үхрийн махны үнэ 21.3 хувь, хонины ястай махны үнэ 24.7 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

### Улаанбаатар хот:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2021 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1.5 хувь, өмнөх оны эцсээс 12.0 хувь, өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар өслөө.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 10.0 хувиар өсөхөд орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 3.0 хувиар буурсан хэдий ч хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 19.1 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 7.0 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 7.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 14.3 хувь, тээврийн бүлгийн үнэ 20.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард өмнөх оны эцсээс 12.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 18.1 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ 6.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 16.9 хувь, тээврийн бүлгийн үнэ 20.4 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.


Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард өмнөх сараас 1.5 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ 2.2 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ 1.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 0.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улаанбаатар хотод 2021 оны 11 дүгээр сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 24.7 хувь буюу 85 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 3.5 хувь буюу 12 бараа, үйлчилгээний үнэ буурч, 71.8 хувь буюу 247 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байна. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 53 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

ЗУРАГ 5. УЛААНБААТАР ХОТЫН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар




ЗУРАГ 6. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЦУЛ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн цул 1 кг махны дундаж үнэ 2021 оны 11 дүгээр сард 14990 төгрөг болж, 2018 оны 11 дүгээр сараас 60.3 хувь, 2019 оны 11 дүгээр сараас 13.1 хувь, 2020 оны 11 дүгээр сараас 15.7 хувиар, өмнөх оны эцсээс 19.4 хувь буюу 2438 төгрөгөөр тус тус өсөж, харин өмнөх сараас 100 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 7. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ҮХРИЙН ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод худалдаалагдаж буй үхрийн ястай 1 кг махны дундаж үнэ 2021 оны 11 дүгээр сард 13342 төгрөг болж, 2018 оны 11 дүгээр сараас 66.7 хувь, 2019 оны 11 дүгээр сараас 32.1 хувь, 2020 оны 11 дүгээр сараас 20.5 хувиар, өмнөх оны эцсээс 19.0 хувь буюу 2133 төгрөг, өмнөх сараас 0.5 хувь буюу 65 төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 8. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр



Улаанбаатар хотод худалдаалагдаж буй хонины ястай 1 кг махны дундаж үнэ 2021 оны 11 дүгээр сард 10773 төгрөг болж, 2018 оны 11 дүгээр сараас 61.1 хувь, 2019 оны 11 дүгээр сараас 39.8 хувь, 2020 оны 11 дүгээр сараас 24.8 хувь, өмнөх оны эцсээс 25.6 хувь буюу 2194 төгрөгөөр, өмнөх сараас 2.1 хувь буюу 233 төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 9. УЛААНБААТАР ХОТОД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ НЭГ ЛИТР АИ-92 БЕНЗИНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сараар, төгрөгөөр




Нэг литр АИ-92 бензиний дундаж үнэ 2021 оны 11 дүгээр сард 2151 төгрөг болж, 2018 оны 11 дүгээр сараас 8.7 хувь, 2019 оны 11 дүгээр сараас 17.1 хувь, 2020 оны 11 дүгээр сараас 50.2 хувь, өмнөх оны эцсээс 50.2 хувь буюу 718 төгрөгөөр, өмнөх сараас 103 төгрөгөөр тус тус өссөн байна.



### Аймаг:

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард өмнөх оны мөн үеэс бүх аймагт 7.5-14.6 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2021 оны 11 дүгээр сард Хөвсгөл аймагт 7.5 хувиар өссөн нь хамгийн бага, Сэлэнгэ аймагт 14.6 хувиар өссөн нь хамгийн өндөр байна.


ЗУРАГ 10. ХЭРЭГЛЭЭНИЙ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС, ХУВЬ, АЙМАГ НИЙСЛЭЛЭЭР, жил бүрийн 11 дүгээр сард (өмнөх оны мөн үеэс)



Аймгуудад худалдаалагдаж буй хонины ястай 1кг махны дундаж үнэ 2021 оны 11 дүгээр сард 9185 төгрөг болж, 2020 оны 11 дүгээр сараас дунджаар 1807 төгрөг, 2020 оны 12 дугаар сараас 1659 төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Хонины ястай 1кг махны дундаж үнэ 2021 оны 11 дүгээр сард Говь-Алтай аймагт 7500 төгрөг байгаа нь хамгийн бага, Ховд аймагт 12000 төгрөг байгаа нь хамгийн өндөр байна.

ЗУРАГ 11. АЙМГУУДАД ХУДАЛДААЛАГДАЖ БУЙ ХОНИНЫ ЯСТАЙ 1 КГ МАХНЫ ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 11 дүгээр сард, төгрөгөөр



### Ойлголт, тодорхойлолт:

**Хэрэглээний сагс:** Үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн дундаж өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалтыг ойлгоно.

**Хэрэглээний бараа, үйлчилгээний жин:** Өрхийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувь.

**Хэрэглээний үнийн индекс:** Хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

### Тооцох аргачлал:

Хэрэглээний үнийн индексийг хэрэглээний сагс, хэрэглээний жин гэсэн хоёр үзүүлэлтийг ашиглан, хувиргасан үнийн Ласпейрсийн индексийн томъёогоор тооцно. Үүнд:

$$I_{ct}^L = \sum \left( \frac{P_{it}}{P_{it-1}} \right) \left( \frac{P_{it-1}}{P_{it-2}} \right) \dots \left( \frac{P_{i2}}{P_{i1}} \right) \left( \frac{P_{i1}}{P_{i0}} \right) \frac{P_{i0} Q_{i0}}{\sum P_{i0} Q_{i0}}$$

$I_{ct}^L$  – тайлант үеийн хувиргасан Ласпейрсийн индекс (t)

t – тайлант үе

i – бараа, үйлчилгээ

o – суурь үе

$P_{it}^i$  - i барааны тайлант үеийн үнэ

$P_{io}^i$  – i барааны суурь үеийн үнэ

$Q_{io}^i$  - i барааны суурь үеийн жин

Хэрэглээний үнийн индексийн сагсны төлөөлөх чадварыг нэмэгдүүлэх, үнэн зөв байдлыг хангах үүднээс хэрэглээний сагс, жинг 5 жилд нэг удаа шинэчилдэг. Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсыг Улаанбаатар хотод 344 бараа, үйлчилгээ (аймагт 238 бараа, үйлчилгээ)-ээр бүрдүүлж, Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны 2015 оны үр дүнгээр жинг тооцон, 2015 оны шинэчилсэн суурьтайгаар 2017 оны 4 дүгээр сараас эхлэн тархааж байна. Хэрэглээний үнийн индексийг тооцохдоо бараа, үйлчилгээний геометр дундаж үнийг ашигласан. Мөн аймгийн дундаж үнийг тооцохдоо сонгогдсон 112 сумын үнийн мэдээллийг хамруулж байна.

Хөдөө аж ахуйн гол нэр төрлийн барааны үнийг сум, аймаг, дүүрэг, нийслэлээс сар бүр цуглуулж байна.



**Эх үүсвэр:**

ҮСХ, Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээ

**Ангилал, код:**

ХЗХБҮА

**Мэдээлэл авах холбоос:**

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

**Дараагийн мэдээ тархаах хуваарь:**

2022 оны 1 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын Үнийн  
статистикийн хэлтсийн статистикч Д.Батсүх,  
Т.Жигжидсүрэн  
Утас : (976-51)-261559

